



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эх болсон зургаан зүйл НҮТББ-ын Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800180 тоот тусгай зөвшөөрөл болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800186 тоот тусгай зөвшөөрлийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР